



ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Цалин хөлсийг шинэчлэн тогтоох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.3.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4, 57.3, Засгийн газрын “Журам батлах тухай” 2018 оны 382 дугаар тогтоолын 1, 2, 3, 5 дугаар хавсралт, “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 2022 оны 487 дугаар тогтоол, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2022 оны 488 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, Сангийн сайдын 2023 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Татварын улсын байцаагч хувцас, хэрэглэл хэрэглэх, цол, түүний нэмэгдэл олгох журам”-ын 3.3, 3.4, 3.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгжийн болон харьяа Мэдээллийн технологийн төвийн төрийн захиргааны албан хаагчдын цалин хөлсийг нэгдүгээр хавсралтаар, Том татвар төлөгчийн газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар хэлтсийн дарга нарын цалин хөлсийг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн тогтоосугай.


2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Татварын ерөнхий газрын даргын 2022 оны А/09 дүгээр тушаалын 1, 3 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Албан хаагчдын цалин хөлсийг 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс хавсралтад заасан хувь хэмжээгээр тооцож олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Бямбадорж), Том татвар төлөгчийн газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Л.Нэргүй)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ



151610344